

# Их Эзэн биднийг Өөрийнх нь Хоёр дахь ирэлтэд дараах байдлаар бэлтгэхэд урьсан . . .

. . . Вавилоныг орхин явах (ёс бус байдал) (Сургаал ба Гэрээ 133:4–5, 7, 12–14-ийг үзнэ үү).

Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч асан Дийтр Ф.Угдорф ийн заажээ.



Эртний Вавилон балгас болсон. Бахдам үзэсгэлэн нь хэдийн үгүй болсон. Гэвч Вавилоны ёс бус явдал, дэлхийн шунал байсаар байна. Итгэлгүй дэлхийн дунд итгэгчид болж амьдрах нь эдүгээ бидэнд оногдсон байна. . . . Бид үеийнхнийхээ дарамт шахалтыг тайван тэвчиж, нийтийг байлдан дагуулагч зүйлс эсвэл хуурамч бошиглогчдын үгсэд үл автан, бурханлаг бус хүмүүсийн тохуурхлыг үл ойшоож, хилэнцэт нэгний уруу таталтыг тэвчин, залхуурлаа даван гарах хэрэгтэй болно. (Дийтр Ф.Угдорф, “Бүү ай, зөвхөн итгэ,” 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 63)

. . . Израилыг цуглуулах (Сургаал ба Гэрээ 133:4, 7–9, 37–38-ыг үзнэ үү).

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон бидэнд ийн сануулжээ.



*Ямар ч үед*, хөшигний аль ч талд байх хэн нэгэнд туслах ямар нэгэн ажлыг хийхэд буюу Бурхантай гэрээ байгуулах, баптисмын болон ариун сүмийн нэн чухал ёслолуудаа хүлээн авах алхам хийхдээ та нар Израилыг цуглуулахад тусалж байгаа хэрэг юм. Энэ бол ийм л энгийн зүйл. (Рассэлл М.Нэлсон, “Израилын найдвар” [Өсвөр үеийнхэнд зориулсан дэлхий даяарх онцгой цугларалт, 2018 оны 6-р сарын 3] [broadcasts.ChurchofJesusChrist.org](https://broadcasts.ChurchofJesusChrist.org)).

. . . наманчилж, Есүс Христээр ариусгагдах (Сургаал ба Гэрээ 133:5–16, 34, 35–62-ыг үзнэ үү).

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвлөх асан Кэрол Ф.Макконки эгч ийн тайлбарласан.



Есүс Христэд болон Түүний Цагаатгалд итгэн, бурханлаг бусаас өөрсдөө татгалзаж, чин сэтгэлээсээ наманчлах үед цэвэр ариун, толбогүй болох боломжтой. Бид нүглээсээ ангижрахын тулд усанд умбуулах баптисм хүртдэг. Биднийг зүрх сэтгэлээ нээж, Ариун Сүнсийг хүлээн авах үед бодгаль маань ариусдаг юм. Долоо хоног бүр бид ариун ёслолоос хүртдэг. Бид Түүний Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд зөв шударга байх чин хүсэлтэй байж, наманчлалын сүнсээр өөрсдөдөө Христийн нэрийг авч, Түүнийг дурсан санаж, зарлигуудыг нь дагахад бэлэн хэмээн гэрээ байгуулдаг. (Кэрол Ф.Макконки, “Ариун байдлын гоо үзэсгэлэн,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 127–128)